



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2008 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

“Даатгалын сургалт явуулах, шалгалт  
авах журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.1.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгалын сургалт явуулах, шалгалт авах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## ДААТГАЛЫН СУРГАЛТ ЯВУУЛАХ, ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос даатгалын мэргэжлийн оролцогч, даатгалын компанийн санхүүгийн тайланд аудит хийх аудитор болон даатгалын актуарч нарт зориулан тусгай зөвшөөрөл, эрх олгох сургалт явуулах, шалгалт авах болон даатгалын чиглэлээр бусад сургалт зохион байгуулах, үүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сургалт нь дараах төрлүүдтэй байна:

- 1.2.1. Даатгалын төлөөлөгчийн сургалт;
- 1.2.2. Даатгалын аудиторын сургалт;
- 1.2.3. Даатгалын актуарчийн сургалт;
- 1.2.4. Бусад сургалт, семинар.

1.3. Энэ журмын 1.2.1, 1.2.2-т заасан сургалтад оролцож, тусгай зөвшөөрөл, эрх авахыг хүссэн этгээд нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Хорооноос баталсан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл болон даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох талаарх харилцааг зохицуулсан журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан байна.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

1.4. Энэ журмын 1.2.3-т заасан сургалтад оролцож, эрх авахыг хүссэн этгээд нь Хорооноос баталсан Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах талаарх харилцааг зохицуулсан журамд заасан бусад нөхцөл шаардлагыг бүрэн хангасан байна.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

1.5. Даатгалын байгууллага нь сургалтын жилийн төлөвлөгөөгөө жил бүрийн 1 дүгээр сард багтаан Хороонд ирүүлнэ. Сургалтын төлөвлөгөөнд Хорооноос зохион байгуулах нэгдсэн сургалтанд ажилтнуудаа оролцуулах болон өөрсдөө хийх сургалтыг тус тус оруулсан байна.

1.6. Даатгалын сургалтыг эрх олгох, мэргэжил дээшлүүлэх гэсэн 2 хэлбэрээр явуулна.

1.7. Энэ журмын 1.6-д заасан мэргэжил дээшлүүлэх сургалт гэдэг нь Хорооноос даатгалын төлөөлөгчийн, даатгалын аудиторын болон даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдэд зохион байгуулах сургалтыг хэлнэ.

1.8. Энэ журмын 1.7-д заасан сургалтыг Монголын даатгагчдын холбоо зохион байгуулж, шалгалтыг авна.

1.9.Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгалын төлөөлөгч болон даатгалын аудитор нь зөвшөөрөл авснаас хойш 3 жил тутамд 1 удаа, даатгалын актуарч нь зөвшөөрөл авснаас хойш 2 жил тутамд 1 удаа тус тус даатгалын мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцоно.

1.10.Энэ журмын 1.9-д заасны дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцоогүй, эсхүл сургалтад оролцоод шалгалтанд тэнцээгүй этгээдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо түдгэлзүүлнэ.

## **Хоёр. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сургалт, тусгай зөвшөөрөл олгох шалгалт**

2.1.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) олгох сургалтыг Монголын даатгагчдын холбоо, эсхүл тухайн даатгалын компани өөрийн даатгалын төлөөлөгчдөд зориулан зохион байгуулна.

2.2.Даатгагч нь даатгалын төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрөө тухайн сургалт явуулахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө Хорооны Ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх)-аар хянуулж, батлуулна.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.3.Даатгагчаас ирүүлсэн даатгалын төлөөлөгчийн сургалтын хөтөлбөрийг Ажлын алба хянаж, нэмэлт өөрчлөлт оруулахаар бол энэ тухай даатгагчид эргэж мэдэгдэнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.4.Ажлын албаар сургалтын хөтөлбөрөө батлуулаагүй, урьдчилж мэдэгдэлгүй явуулсан аливаа сургалтыг даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох сургалтанд тооцохгүй.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.5.Даатгалын компаниас ирүүлсэн даатгалын төлөөлөгчийн сургалтын хөтөлбөрт дараах зүйлийг тусгасан байвал зохино:

2.5.1.Сургалтын нэр;

2.5.2.Сургалтын төрөл, хэлбэр;

2.5.3.Сургалт явагдах хугацаа;

2.5.4.Сургалт зохион байгуулах байгууллага, сургалт явагдах газар;

2.5.5.Сургалтын зорилго, товч агуулга;

2.5.6.Сургагч багшийн нэрс;

2.5.7.Сургалтад хамрагдах хүмүүсийн тоо;

2.5.8.Сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөө.

2.6.Энэхүү журмын 2.5.8-д заасан сэдэвчилсэн төлөвлөгөөг энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргаж ирүүлнэ.

2.7.Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн этгээд нь 16-гаас доошгүй цагийн сургалтад оролцсон байна:

2.7.1.Сургалтын хичээлийн 1 цаг нь 45 минут байна.

2.8.Энэхүү журмын 2.5.8-д заасан сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөөнд Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, зааврын талаар тусгасан байна.

2.9.Улаанбаатар хотод зохион байгуулагдах даатгалын төлөөлөгчийн сургалтанд Хорооноос томилогдсон төлөөлөгч хяналт тавьж оролцоно.

2.10.Аймаг орон нутагт зохион байгуулагдах даатгалын төлөөлөгчийн сургалтанд Хорооноос тухайн аймагт томилогдсон орон нутгийн төлөөлөгч хяналт тавьж оролцоно.

2.11.Даатгалын төлөөлөгчийн сургалтад оролцож, энэхүү журмын 2.7-д заасан сургалтын цагийг хангаж, гэрчилгээ авсан этгээдээс Хорооны Ажлын албаны дарга (цаашид “Ажлын албаны дарга” гэх)-ын тушаалаар батлагдсан шалгалтын комисс шалгалт авна.

2.12.Шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг Ажлын албаны даргын тушаалаар шалгалт авах тухайн бүрд батална.

2.13.Даатгалын төлөөлөгчийн эрх олгох шалгалтын тестийн асуултыг Ажлын алба боловсруулж, шалгалт авах хугацааг тогтооно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.14.Ажлын алба Улаанбаатар хотод явагдсан сургалтын шалгалтын материалыг ажлын 1 өдрийн дотор, аймаг орон нутагт явагдсан сургалтын шалгалтын материалыг хүлээж авсан өдрөөс хойш 1 өдрийн дотор тус тус хянаж, шалгалтын дүнг даатгагчид мэдэгдэнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.15.Аймаг орон нутагт явагдсан даатгалын төлөөлөгчийн сургалтын шалгалтын материалыг Хорооны орон нутаг дахь төлөөлөгч ажлын 1 өдрийн дотор хянаж, тайлан материалыг 7 хоногийн дотор Ажлын албанд хянуулахаар хүргүүлнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.16.Шаардлагатай гэж үзвэл аймаг орон нутагт зохион байгуулагдах даатгалын төлөөлөгчийн сургалтад Ажлын албаны мэргэжилтэн томилолтоор явж, газар дээр нь хяналт тавьж оролцоно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.17.Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д заасан даатгалын төлөөлөгчид тавигдах шаардлагыг хангасан, даатгалын төлөөлөгчийн сургалтад оролцож, шалгалтад тэнцсэн этгээдэд Хорооны даргын тушаалаар даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгоно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

**Гурав. Даатгалын аудит хийх эрх олгох сургалт, аудиторт даатгалын**

## **байгууллагад аудит хийх эрх олгох шалгалт**

3.1.Аудиторт даатгалын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх эрх олгох аудиторын сургалт (цаашид “даатгалын аудиторын сургалт” гэх)-ыг Хорооноос баталсан даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох талаарх харилцааг зохицуулсан журамд заасны дагуу Хороо зохион байгуулна.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

3.2.Хороо даатгалын аудиторын сургалтын хугацаа, газар болон сургалтын талаарх бусад мэдээллийг сургалт эхлэхээс 14 хоногийн өмнө аудитын компаниудад мэдээлнэ.

3.3.Даатгалын байгууллагад аудит хийх эрх авахыг хүссэн аудитор нь Хорооноос баталсан даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох талаарх харилцааг зохицуулсан журамд заасан шаардлагыг хангасан байхаас гадна дээрх журамд заасан баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

3.4.Даатгалын аудиторын сургалтын хөтөлбөрийг Ажлын алба боловсруулж Ажлын албаны даргаар батлуулна.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

3.5.Даатгалын аудиторын сургалтын хөтөлбөр нь Даатгалын тухай хууль болон даатгалын багц дүрэмд нийцсэн байна.

3.6.Даатгалын аудиторын сургалтад оролцож эрх авахыг хүссэн этгээд нь 10-аас доошгүй цагийн сургалтанд оролцсон байна.

3.7.Сургалтын цагийг энэхүү журмын 2.7.1-д зааснаар тооцно.

3.8.Хорооноос зохион байгуулсан даатгалын аудиторын сургалтад оролцож, энэ журмын 3.6-д заасан сургалтын цагийг хангасан этгээдээс Ажлын албаны даргын тушаалаар батлагдсан шалгалтын комисс даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох шалгалт авна.

3.9.Энэ журмын 3.8-д заасан шалгалтын тестийн асуултыг Ажлын алба боловсруулж, шалгалт авах хугацаа, газрыг тогтооно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

3.10.Ажлын алба аудиторт даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох шалгалтын материалыг ажлын 1 өдрийн дотор хянаж, хариуг тухайн шалгалт өгсөн этгээдэд мэдэгдэнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

3.11. ~~Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон Хорооны 2006 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Аудиторт даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох тухай журам” д заасан шаардлагыг хангасан, даатгалын аудиторын~~

~~сургалтад оролцож, энэхүү журмын 3.8-д заасан шалгалтад тэнцсэн аудиторт Хорооны нийдвэрээр даатгалын байгууллагад аудит хийх эрх олгоно.~~

~~*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*~~

#### **Дөрөв. Даатгалын актуарчийн сургалт, даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалт**

4.1. Хорооноос баталсан Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах талаарх харилцааг зохицуулсан журмаар зохицуулна.

~~*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*~~

4.2. Актуарчийн сургалтыг Хорооноос зохион байгуулж болно.

4.3. Хороо энэ журмын 4.2-т заасан актуарчийн сургалтын хугацаа, газар болон сургалтын талаарх бусад мэдээллийг сургалт эхлэхээс 14 хоногийн өмнө даатгалын байгууллагуудад мэдээлнэ.

4.4. Актуарчийн сургалтын хөтөлбөрийг Ажлын алба боловсруулж, Ажлын албаны даргаар батлуулна.

~~*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*~~

4.5. Актуарчийн сургалтын хөтөлбөр нь Даатгалын тухай хууль болон даатгалын багц дүрэмтэй нийцсэн байна.

4.6. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авахыг хүссэн этгээд нь 40-өөс доошгүй цагийн сургалтад оролцсон байна.

4.7. Сургалтын цагийг энэхүү журмын 2.7.1-д зааснаар тооцно.

4.8. Хорооноос зохион байгуулсан даатгалын актуарчийн сургалтад оролцож энэхүү журмын 4.6-д заасан сургалтын цагийг хангасан этгээдээс Ажлын албаны даргын тушаалаар батлагдсан шалгалтын комисс шалгалт авна.

4.9. Энэхүү журмын 4.8-д заасан шалгалтын асуултыг Ажлын алба боловсруулж шалгалт авах хугацаа, газрыг тогтооно.

~~*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*~~

4.10. Ажлын алба актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалтын материалыг ажлын 3 өдрийн дотор хянаж, хариуг тухайн шалгалт өгсөн этгээдэд мэдэгдэнэ.

~~*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*~~

~~4.11. Даатгалын тухай хууль болон Хорооны 2007 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам” д заасан шаардлагыг хангасан, даатгалын актуарчийн сургалтад оролцож, энэхүү журмын 4.8 д~~

~~заасан шалгалтад тэнцсэн актуарчид Хорооны шийдвэрээр даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно.~~

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

### **Тав. Бусад**

5.1.Хорооноос зохион явуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, төсөв зохиож Ажлын албаны даргаар батлуулах, сургалтын талаар нийтэд мэдээлэхийг Ажлын алба хариуцна.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.2.Энэхүү журмын 1.2.1, 1.2.2, 1.2.3- т зааснаас бусад сургалтыг Ажлын албанаас зохион байгуулах бөгөөд сургалтын хөтөлбөр болон төсөв боловсруулж батлуулах асуудлыг Ажлын алба тухайн бүрд Ажлын албаны даргад танилцуулж зөвшөөрөл авна.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.3.Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хуулийн 83.1.32 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 45.1.14-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--

